

ЭДИЙН ЗАСГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН
АРГА ХЭЛБЭРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Б. Бүрэнжаргал *

* МХХ-гийн багш, магистр, КТМС-ийн докторант

Түлхүүр үг: эдийн засгийн сэтгүүл зүй, сэтгүүл зүйн сургалт, хичээлийн хөтөлбөр, эдийн засаг, бизнесийн сурвалжлага.

1. Эдийн засгийн сэтгүүл зүйн сургалтыг шинэчлэх шаардлага

Их, дээд сургуулийн сэтгүүл зүйн ангид суралцаж байгаа хорин гурван оюутнаас эдийн засгийн онол, эдийн засгийн сэтгүүл зүйн талаар ерөнхий асуулт бүхий тандалт, судалгаа явуулахад судалгаанд оролцогчдын 70% нь эдийн засгийн асуудлыг сонирхдог гэжээ. Гэтэл тэдний тал хувь нь эдийн засгийн онолын хичээл үзээгүй, энэ хичээлийг үзнэ гэж хөтөлбөрт байхгүй гэсэн байна. Сэтгүүлч нарт эдийн засгийн мэдлэг хэрэгтэй юу гэсэн асуултад нэг ч оюутан шаардлагагүй, огт хэрэггүй гэж хариулаагүй байна.

Эдийн засгийн сэтгүүл зүйн хичээлийн хувьд тэдний 65% нь энэ хичээлийг үзээгүй гэж хариулсан бөгөөд тэдний 30% нь үзнэ гэж хөтөлбөрт тусгаагүй гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 56% нь эдийн засгийн сэтгүүл зүйн хичээл чухал шаардлагатай, 40% нь байж болох л юм, дөрвөн хувь буюу нэг л оюутан энэ хичээлийг шаардлагагүй гэж үзсэн байна.

Эдийн засгийн мэдээ, сурвалжлага хийж чадах уу? гэсэн асуултад чадна гэсэн нэг ч хариулт авсангүй. Харин 40% нь хийхийг хичээнэ, 60% нь эргэлзэж байна гэсэн хариултыг өгчээ.

Мөн өдөр тутмын найман сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга нарын дунд тандалт судалгаа явуулсан юм. Хамгийн олон захиалагчтай болох "Өдрийн сонин" болон "Үнэн" сонин эдийн засгийн асуудал хариуцан бичдэг албагүй гэсэн байна. Тэд сэтгүүлчдийн эдийн засгийн мэдлэг дутмаг, эдийн засгийн асуудлыг дагнан бичих сэтгүүлчдийн ур чадвар тааруу байдаг нь ийм албагүй байх гол шалтгаан гэж үзэж байна.

Эдийн засгийн сэдвээр дагнан бичдэг сэтгүүлч хэр шаардлагатай байгаа талаарх асуултад 100% чухал шаардлагатай гэсэн хариулт өгчээ. Сургууль төгсөөд ирж байгаа

сэтгүүлчдийн эдийн засгийн мэдлэгийн төвшин хэр байдаг тухай асуултад 75% нь шаардлага хангадаггүй, 25% нь тэд огт ойлголтгүй ирдэг гэсэн байна. Мөн ажиллаж буй сэтгүүлчдэд эдийн засгийн сургалт хэрэгтэй эсэх талаар асуухад 37.5% нь маш их, 62.5% нь ер нь хэрэгтэй байна гэж үзэж байна.

Дээрх судалгаануудын дүн нь сэтгүүл зүйн сургалт явуулж байгаа их, дээд сургуулиуд эдийн засгийн сэтгүүл зүйн хичээлийн хөтөлбөр, сургалтын заах арга зүйдээ анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Эдийн засаг, бизнесийн асуудал нь улс орны төдийгүй, дэлхий нийтийг хамарсан макро, микро төвшний асуудлыг өөрөөр хэлбэл, өрхийн аж ахуйгаас эхлээд компаниудыг оролцуулаад тэдний орлогыг хэрхэн нэмэгдүүлэх, улсын төсвийг яаж бүрдүүлж, түүнийг хэрхэн зөв зарцуулж байна, ашиг орлоготой байхад гадаад, дотоодын зах зээлийн хүчин зүйлүүд хэрхэн өөрчлөгдөж байна гэх мэт маш өргөн хүрээг хамарч байдгаараа онцлог юм. Нөгөө талаас эдийн засгийн өсөлт бууралт, үнэ ханш, хөрөнгө оруулалт, үр ашиг гэх мэт үзүүлэлтүүд нь олон оронтой тоо, янз бүрийн хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэж байдаг учир гэдгээрийг олон нийтэд энгийн ойлгомжтой хүргэхэд эдийн засгийн үндсэн мэдлэг, ур чадварыг сэтгүүлчдээс шаарддаг.

2. Эдийн засгийн сэтгүүл зүйн хичээлийн хөтөлбөрийг цогцоор авч үзэх нь

2.1. Эдийн засгийн онолын хичээлийг сэтгүүл зүйн оюутнуудад заах онцлог

Эдийн засгийн сэтгүүл зүйн сургалтыг явуулахад оюутнуудад эдийн

засгийн ерөнхий ойлголтыг өгсөн байх нь чухал бөгөөд энэ нь:

- нэг талаас юун тухай бичиж байгаага мэдэхгүй байх нь уншигч, үзэгчдэд ташаа мэдээлэл өгөх, асуудлыг буруу тайлбарлах зэрэг алдаа гаргах гол шалтгаан нь болдог,

- нөгөө талаас эдийн засгийн сэтгүүл зүйн гол зорилгын нэг бол эдийн засгийн мэдээ, мэдээллээр уншигчдад давхар мэдлэг олгож байх явдал байдаг зэрэгтэй холбоотой юм.

Гэхдээ бид эдийн засгийн мэдээ мэдээллийг голдуу макро эдийн засгийн хэдэн үзүүлэлтээр хязгаарлаж ойлгодог сөрөг хандлагад дассан байгаа нь энэ сэдвийг хүнд, ойлгомжгүй, бичихэд төвөгтэй гэх мэт ойлголтыг оюутнуудад өгч болох талтайг анхаарах нь зүйтэй юм. Тийм учраас сэтгүүл зүйн чиглэлээр сурч байгаа оюутнуудад "эдийн засгийн онол"-ын хичээлийг заахдаа дараах хэдэн зүйлийг анхаарах нь зүйтэй юм. Үүнд:

- Эдийн засгийн онолын олон томъёолол, эдийн засгийн хууль, категориудыг бүгдийг нь мэдэх албагүй болохыг анхаарах, өөрөөр хэлбэл эдийн засгийн мэргэжлийн оюутнуудад заадаг лекцээс арай энгийн хялбар ойлгогдохоор байх гэх мэт;

- Эдийн засгийн ойлголтуудыг амьдралын жишээ, баримт дээр тулгуурлан ойлгуулах, тухайлбал өөрсдөөр нь жижиг бизнесийн тооцоо хийлгэж үйлдвэрлэл явуулахад шаардагдах хүчин зүйлүүдийг нь ойлгуулах, бизнесээ ашигтай, зөв явуулахад нь эрх зүйн ямар орчин байгааг мэдрүүлэх гэх мэтээр багаар ажиллуулах;

- Макро ба микро төвшний эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн утга учрыг

нарийн ойлгуулах, эргээд тайлбарлах чадварыг эзэмшүүлэх. Жишээ нь эдийн засгийн хөгжлийг хэмжих гол үзүүлэлт бол нэг хүн амд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээ, ДНБ гэдэг нь тухайн улсын ард иргэдийн, тухайн жилд тэдний хөдөлмөрөөр бий болсон баялгийг хэлж байгааг ойлгуулах, микро төвшний гол үзүүлэлт бол тухайн үйлдвэр, үйлчилгээний ашиг байдаг, түүнд татварын ямар ямар дарамт, эсвэл хөнгөлөлт үйлчилж байна гэх мэт;

- Эдийн засгийн үзүүлэлтүүдийг хэмжих нэгж, тэдгээрийн динамик өөрчлөлтийг харьцуулж сурах дадал эзэмшүүлэх, үүнд аливаа тоо, цифр нь дангаараа ямар нэг утга илэрхийлэхгүй, заавал хэмжих нэгжтэй нь ашиглаж сурах, мөн дан тоо нь ач холбогдол багатай,

эсвэл урьд онтой нь, эсвэл өөр нэг зүйлтэй харьцуулж ойлгох дадал эзэмшүүлэх, ДНБ-ийг тооцохдоо яагаад заавал тодорхой нэг оны суурь үнээр бодож байгааг тайлбарлаж ойлгуулах гэх мэт;

- Эдийн засгийн үзэгдлүүдийн уялдаа холбоог орчин үеийн жишээ, баримтууд дээр түшиглэн ойлгуулах, тухайлбал ядуурал гүнзгийрээд байна, ядуурлаас гарах гол арга зам нь орлогын өөр ямар эх үүсвэр байгааг олж харах, шинэ шинэ арга замууд зах зээлийн нийгэмд байна. Үүнд үнэт цаасны зах зээл, хөрөнгийн зах зээл,

санхүүгийн үйлчилгээ, лизингийн үйлчилгээ тэдгээрийн давуу ба сул талуудыг тайлбарлаж ойлгуулах гэх мэт заах арга зүйн хандлага байж болох юм.

Энэ нь оюутнуудад эдийн засгийн асуудлыг сонирхох сэдлийг төрүүлэх, эдийн засгийн мэдээ, сурвалжлага бичих асуудлаа зөв олж харах чадвартай болох, эдийн засгийн хүнд сэдвийг уншигч, үзэгчдэд энгийн хүргэх

боломжийг нь нээж өгөх зэрэг ач холбогдолтой байх болно.

Ер нь тухайн улсын эдийн засагт гол зангилаа, тулгамдсан асуудал нь юу байна гэдгийг тооцоолж тэр талаарх ойлголтыг оюутнуудад түлхүү өгөхөд анхаарахад илүүдэхгүй юм.

Манай улсын эдийн засаг нь өөрөө төвлөрсөн

төлөвлөгөөт зарчмаас зах зээлийн харилцаанд шилжиж, шинээр төлөвшиж байгаа, ингэхдээ жам ёсоороо хөгжсөн зах зээлийн эдийн засаг биш, ихэнх тохиолдолд төрийн бодлогоор өөрөөр хэлбэл, цөөхөн тооны хүмүүсийн субъектив үзэл бодлоор эдийн засгийн бодлого, арга хэмжээнүүд нь хөтлөгдөн явсан нь сүүдэр эдийн засаг бий болох гол нөхцөл болоод байгаа билээ. Манай улсын хүн амын гурван хүн тутмын нэг нь ядуу байна гэдэг нь үүнийг батлах бодит жишээ болоод байна. Тийм учраас ядуурлыг бий болоход юу нөлөөлж байна, хэрхэн

«

Эдийн засгийн үзэгдлүүдийн уялдаа холбоог орчин үеийн жишээ, баримтууд дээр түшиглэн ойлгуулах, тухайлбал ядуурал гүнзгийрээд байна, ядуурлаас гарах гол арга зам нь орлогын өөр ямар эх үүсвэр байгааг олж харах, шинэ шинэ арга замууд зах зээлийн нийгэмд байна.

»

ядуурлаас гарч болох тухай асуудлыг олж харах чадвартай байх гэх мэт оюутнуудын эдийн засгийн сэтгэлгээг нийгмийн тухайн үеийн тулгамдсан асуудалд нь түшиглэн хөгжүүлж болно.

2.2. Эдийн засгийн сэтгүүл зүйн сурвалжтын онцлог

Өдөр тутмын сониндээд онд гэсэны редакцийн удирдлагуудын дунд явуулсан судалгаанаас манай хэвлэл мэдээллийн байгууллагуудад эдийн засгийн мэдлэгтэй, эдийн засгийн мэдээ, сурвалжлагыг бичих ур чадвартай сэтгүүлч маш чухал хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна. Энэ хэрэгцээг хангах үүрэг сэтгүүл зүйн сургалт явуулж буй их, дээд сургуулиудад оногдож байна. Үүний тулд дээр бидний авч үзсэнчлэн эдийн засгийн онолын сургалтыг явуулахаас гадна дараах зүйлд анхаарах нь зүйтэй болов уу. Үүнд:

1. Эдийн засаг, бизнесийн сурвалжлага хийх дадлага эзэмшүүлэх,

2. Оюутнуудыг зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нь биш, тодорхой мэргэжлийн чиглэлээр, тухайлбал эдийн засгийн, хууль эрх зүйн гэх мэт нийгэмд чухал шаардлагатай байгаа мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэн бэлтгэх гэх мэт.

Сэтгүүлч нарыг эдийн засгийн чиглэлээр дагнан бичиж сургахад Нээлттэй Нийгэм Форум нилээд анхаарал тавьж энэ талаар хэд хэдэн сургалт зохион байгуулж, гарын авлага¹ бэлтгэн гаргаад байгаа нь энэ чиглэлээр оюутныг сургахад тэдгээрийг ашиглах боломжийг нээж өгөөд байна. Мөн Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлагаас "Бизнес, эдийн засгийн сурвалжлага хийх талаарх арван практик зөвлөгөө"² гэсэн гарын

авлагыг хэвлүүлсэн байгаа нь эдийн засгийн сэтгүүл зүйн хичээл заах багш нарт үнэтэй тус болох юм.

"Улаанбаатар-Эрдэм-Оюу" сургуулийн багш Д.Ганболд энэ онд "Эдийн засгийн сэтгүүл зүй"³ гэсэн гарын авлагыг хэвлүүлэн гаргажээ. Уг номонд эдийн засгийн сэтгүүл зүйн үүрэг, эдийн засгийн сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл, эдийн засгийн нэр томъёоны тайлбар зэргийг багтааснаараа сайн талтай байна. Гэвч уг номны "2.1 Эдийн засгийн сэтгүүл зүйн эрх зүйн орчин" гэсэн хэсэгт "эдийн засгийн мэдээлэлд зайлшгүй байх гол элементийн нэг нь ашгийн төлөө эсвэл улс орны хөгжлийн төлөө төрөөс гаргасан хэрэгжиж болох эрх зүйн заалт, дүрэм журам юм..." гэх мэт бичсэн байгаа нь гарчгийн утга, бичиж буй зүйлийнхээ агуулгатайгаа зөрчилдөж байна. Энэ номонд мөн зөв бичгийн алдаа нилээд байгааг дурдахгүй өнгөрч боломгүй санагдана. Энэ нь эдийн засгийн сэтгүүл зүйн асуудлаар судалгаа хийж буй болон сургалт, хичээл явуулдаг багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, санаа бодлоо солилцох асуудал чухал байгааг харуулж байна.

Эдийн засгийн сэтгүүл зүйн хичээлийг аль болох практик талаас нь түлхүү орох нь зүйтэй гэсэн саналтай байна. Учир нь оюутнууд сэтгүүл зүйн талаасаа ч тэр, эдийн засгийн онолын талаасаа ч тэр зохих хэмжээний суурь мэдлэгтэй болсон үед уг хичээлийг оруулж байгаагаараа онцлог байгаа юм.

Эдийн засгийн сэтгүүл зүйн хичээлийг практик талаас нь заахад дээр дурдсан гарын авлагуудыг ашиглах боломжтойгоос гадна:

• Эдийн засгийн амьдралыг дээд төвшнээс биш, хүмүүсийн өдөр тутмын амьдрал дундаас олж хардаг чадвар эзэмшүүлэх,

• Хэвлэл мэдээллээр нийтэлж, нэвтрүүлж буй эдийн засгийн мэдээ, сурвалжлагад шүүмж хийлгэх, тэдгээрийг хэрхэн сайжруулах тал дээр ажиллуулах,

• Тоо баримттай нягт, нямбай ажиллаж сурах, тоо дангаараа утга илэрхийлэхгүй, орон зай, цаг хугацаа, хэмжих нэгжтэй байж сая хүнд хэрэгтэй болно гэдгийг сайн ойлгуулах гэх мэт үндсэн зарчмуудыг эзэмшүүлэх нь чухал юм.

Ишлэл

¹ Ш и ф ф р и н А., Ф р и й н и й М., Ф о л л е Ж. 2005. Бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлага; 2005. Сэтгүүлчдийн Олон Улсын Төв. Нээлттэй Нийгэм Форумын "Эдийн засаг, бизнесийн асуудлаар бичих нь".

² Олон улсын сэтгүүлчдийн төвөөс Хөгжиж буй улс орнуудад зориулан гаргасан байна.

³ Г а н б о л д Д. 2005. Эдийн засгийн сэтгүүл зүй. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2005. Бизнес, эдийн засгийн сурвалжлага хийх талаарх арван практик зөвлөгөө. УБ.
2. Г а н б о л д Д. 2005. Эдийн засгийн сэтгүүл зүй. УБ.
3. Ш и ф ф р и н А., Ф р и й н и й М., Ф о л л е Ж. 2005. Бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлага.
4. 2005. Эдийн засаг, бизнесийн асуудлаар бичих нь. УБ.

Резюме

На основе социологического опроса студентов факультета журналистики и ответственных работников ежедневных газет, автор статьи рассматривает вопросы о необходимости развития экономической журналистики в Монголии. Для этого считает автор, необходимо пересмотреть не только методы и программы обучения экономической журналистики на факультетах журналистики, но и принять различные меры для повышения интересов работающих журналистов писать на тему экономики.